



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/10/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Аудитор: Ц.Цэрэнхүү
Утас: 261740 Цахим хаяг: tserenhuuts@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	13
3.5.1 Мөнгөн хөрөнгө	13
3.5.2 Авлага	14
3.5.3 Урьдчилгаа	14
3.5.4 Бараа материал.....	15
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	16
3.5.6 Өр төлбөр.....	16
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,	17
3.6.1 Төсвийн төлөвлөлт	17
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Харьяа байгууллагууд.....	21
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	22
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа	22
4.2.2 Зөвлөмж	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГГ	Гаалийн газар
ГХ	Гаалийн хороо
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УХШИГГ	Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар
УБГГ	Улаанбаатар гаалийн газар
ЧХОУНБ	Чингис хаан олон улсын нисэх буудал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.АСРАЛТ ТАНАА

2022, 03.25 № 07/701
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Гаалийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,715,765.3	32,613,009.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,796,681.5	1,912,475.5
33	АВЛАГА	61,551.4	80,725.1
34	УРЬДЧИЛГАА	31,626.0	62,015.8
35	БАРАА МАТЕРИАЛ	4,388,063.1	4,521,753.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	22,437,843.1	26,036,039.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	134,198,975.0	132,915,939.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	134,198,975.0	132,915,939.3
39200	Биет хөрөнгө	127,781,498.2	126,388,381.3
39300	Биет бус хөрөнгө	6,417,476.7	6,527,558.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	164,914,740.2	165,528,949.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,252,673.4	1,852,388.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,252,673.4	1,852,388.0
41300	Өглөг	3,252,673.4	1,852,388.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	161,662,066.9	163,676,561.0
51	Засгийн газрын хувь оролцоо	161,662,066.9	163,676,561.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71,069,406.4	71,160,406.4
51200	Хуримтлагдсан үр дүн	83,707,074.9	85,597,658.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,885,585.5	6,918,496.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	164,914,740.2	165,528,949.0

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	107,431,886.3	71,121,229.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,408,341.7	10,710,670.4
120	Нийтлэг татварын бус орлого	16,403,362.2	10,710,670.4
122	Туламжийн орлого	4,979.5	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	91,023,554.6	60,410,558.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	64,202,380.8	69,058,144.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,202,380.8	69,058,144.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,806,673.7	52,310,787.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,131,287.8	26,130,546.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,202,377.8	3,453,872.3
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	2,246,622.9	1,703,302.0
2104	Хангамж, бараа материалын зардал	884,235.8	984,545.5
2105	Нормативт зардал	1,155,432.6	507,027.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,046,399.5	1,517,133.0
2107	Томилолт, зочны зардал	100,845.9	136,007.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,620,712.4	3,014,365.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,418,759.0	14,863,987.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,395,707.0	16,747,357.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	43,229,505.5	2,063,084.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	63,182.0	175,603.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	43,166,323.6	1,887,481.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	107,409,713.8	71,141,864.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,359,894.3	10,731,305.5
120	Нийтлэг татварын бус орлого	16,359,894.3	10,731,305.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	91,049,819.6	60,410,558.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,743,153.5	56,795,605.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,743,153.5	56,795,605.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,880,168.0	40,537,319.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,891,187.7	25,937,609.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөөх шимтгэл	3,199,551.9	3,427,004.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,254,952.3	1,678,165.0
2104	Хангамж, бараа материалын зардал	811,989.7	892,287.0
2105	Нормативт зардал	832,492.3	491,817.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,608,658.6	1,887,066.2
2107	Томилолт, зочны зардал	80,908.6	135,989.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,131,140.7	3,165,113.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,069,286.2	2,922,267.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,862,985.5	16,258,286.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	57,666,560.4	14,346,258.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	55,205,519.1	16,230,464.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,205,519.1	16,230,464.5
2200	Дотоод эх үүсвэрээр	55,205,519.1	16,230,464.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (V)	-55,205,519.1	-16,230,464.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,461,041.2	-1,884,206.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,335,640.3	3,796,681.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,796,681.5	1,912,475.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,656,792.0	0.0	117,656,792.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,130.6	0.0	-1,130.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,655,661.3	0.0	117,655,661.3
9	Тайлант үеийн үр дүн	43,166,323.6	0.0	43,166,323.6
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	161,662,066.9	0.0	161,662,066.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,101.6	0.0	3,101.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	161,665,168.5	0.0	161,665,168.5
17	Өмчид гарсан өөрчлөлт	123,911.0	0.0	123,911.0
19	Тайлант үеийн үр дүн	1,887,481.4	0.0	1,887,481.4
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	163,676,561.0	0.0	163,676,561.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,223,566,400.00	46,019,305,482.48	15,204,260,917.52	75.0
УРСГАЛ ЗАРДАЛ	54,997,726,300.00	39,838,745,645.00	15,158,980,654.34	72.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,730,760,300.00	38,767,848,658.26	14,962,911,641.74	72.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,962,923,400.00	25,937,609,300.92	6,025,314,099.08	81.1
Үндсэн цалин	17,296,361,500.00	14,224,351,447.21	3,072,010,052.79	82.2
Нэмэгдэл	8,027,050,400.00	7,291,049,701.46	736,000,698.54	90.8
Унаа хоолны хөнгөлөлт	1,939,426,300.00	1,746,911,413.41	192,514,886.59	90.0
Урамшуулал	4,700,085,200.00	2,675,296,738.84	2,024,788,461.16	56.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,150,037,100.00	3,427,004,314.64	723,032,785.36	82.5
Тэтгэврийн даатгал	2,717,365,000.00	2,438,329,354.08	279,035,645.92	89.7
Тэтгэмжийн даатгал	307,410,200.00	188,465,869.45	118,944,330.55	61.3
ҮОМШӨ-ний даатгал	448,959,600.00	318,901,804.37	130,057,795.63	71.0
Ажилгүйдлийн даатгал	61,481,900.00	47,116,105.97	14,365,794.03	76.6
Эрүүл мэндийн даатгал	614,820,400.00	434,191,180.77	180,629,219.23	70.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,568,698,800.00	1,678,164,952.30	2,890,533,847.70	36.7
Гэрэл, цахилгаан	2,232,028,800.00	941,349,669.23	1,290,679,130.77	42.1
Түлш, халаалт	1,223,547,100.00	556,464,831.66	667,082,268.34	45.4
Цэвэр, бохир ус	273,258,200.00	88,685,451.41	184,572,748.59	32.4
Байрны түрээс	839,864,700.00	91,665,000.00	748,199,700.00	10.9
Хангамж, бараа материалын зардал	970,220,400.00	922,797,059.25	47,423,340.75	95.1
Бичиг хэрэг	135,890,500.00	132,526,566.00	3,363,934.00	97.5
Тээвэр, шатахуун	398,067,100.00	394,955,669.00	3,111,431.00	99.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,607,900.00	56,055,055.25	14,552,844.75	79.3
Ном, хэвлэл	65,465,000.00	38,221,800.00	27,243,200.00	58.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	53,375,200.00	36,115,015.00	17,260,185.00	67.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	246,814,700.00	264,922,954.00	-18,108,254.00	107.3
Нормативт зардал	830,410,300.00	491,817,724.00	338,592,576.00	59.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,382,000.00	23,289,224.00	92,776.00	99.6
Хоол, хүнс	62,175,000.00	53,176,100.00	8,998,900.00	85.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл	744,853,300.00	415,352,400.00	329,500,900.00	55.7
Эд хогшил, урсгал засварын зардал	5,656,216,500.00	2,712,224,126.30	2,943,992,373.70	47.9
Багаж, техник, хэрэгсэл	1,634,639,200.00	413,679,684.00	1,220,959,516.00	25.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,189,627,300.00	734,494,557.60	1,455,132,742.40	33.5
Урсгал засвар	1,831,950,000.00	1,564,049,884.70	267,900,115.30	85.3
Томиллолт, зочны зардал	187,272,500.00	135,988,828.00	51,283,672.00	72.6
Дотоод албан томиллолт	187,272,500.00	135,988,828.00	51,283,672.00	72.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,805,468,500.00	3,264,129,963.24	541,338,536.76	85.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,897,434,600.00	2,765,681,576.93	131,753,023.07	95.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	22,442,000.00	11,938,000.00	10,504,000.00	53.1
Даатгалын үйлчилгээ	101,285,100.00	66,831,471.00	34,453,629.00	65.9
Тээврийн хэрэгслийн татвар	40,951,700.00	7,501,870.00	33,449,830.00	18.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	6,559,500.00	2,408,923.00	4,150,577.00	36.7

Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн,
аудитын тайлан

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	498,457,200.00	266,982,144.31	231,475,055.69	53.5
Газрын төлбөр	18,922,300.00	15,389,838.00	3,532,462.00	81.3
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	219,416,100.00	127,396,140.00	92,019,960.00	58.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,599,512,800.00	198,112,389.61	1,401,400,410.39	12.3
Бараа үйлчилгээний бусад зардал	1,202,616,600.00	156,075,225.91	1,046,541,374.09	12.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	396,896,200.00	42,037,163.70	354,859,036.30	10.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,266,966,000.00	1,070,896,987.40	196,069,012.60	84.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	88,482,200.00	81,231,361.40	7,250,838.60	91.8
Засгийн газрын гадаад шилжүүлэг	88,482,200.00	81,231,361.40	7,250,838.60	91.8
Бусад урсгал шилжүүлэг	1,178,483,800.00	989,665,626.00	188,818,174.00	83.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,013,070,300.00	853,321,218.00	159,749,082.00	84.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	165,413,500.00	136,344,408.00	29,069,092.00	82.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,225,840,100.00	6,180,559,836.82	45,280,263.18	99.2
Барилга байгууламж	5,225,840,000.00	5,180,559,836.82	45,280,163.18	99.1
Тоног төхөөрөмж	1,000,000,100.00	1,000,000,000.00	100.00	100
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,223,566,400.00	46,019,513,882.48	15,204,052,517.52	75.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,996,419,200.00	44,893,163,888.12	15,103,255,311.88	74.8
Улсын төсвөөс санхүүжих	59,996,419,200.00	44,893,163,888.12	15,103,255,311.88	74.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,227,147,200.00	1,126,349,994.36	100,797,205.64	91.8
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,227,147,200.00	1,126,349,994.36	100,797,205.64	91.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	240,800.70	-240,800.70	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	449,200.70	-449,200.70	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,822	1,460	362	80.1
Удирдах ажилтан	68	68	-	100
Гүйцэтгэх ажилтан	1,445	1,012	433	70.0
Үйлчлэх ажилтан	309	380	-71	122.9
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,822	1,460	362	80.1
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	1,458	1,080	378	74.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	364	380	-16	104.4

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		803,187,092.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		72,574,590.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		35,820,585.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		35,820,585.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		31,000,000.00
	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,820,585.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		36,754,005.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		5,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		31,754,005.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		31,754,005.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		730,612,501.50
2200	Дотоод эх үүсвэрээр		730,612,501.50
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		730,612,501.50
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		803,187,092.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		803,187,092.00
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		798,187,092.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх, он удаан жил болсон авлагыг барагдуулах, харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байх, дотоод хяналтыг сайжруулахад анхаарч ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд аудитор Ц.Цэрэнхүү гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор П.Чанцалдулам, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Гаалийн Ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн өдрийн 01/553 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилго нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах;
- Бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх;
- Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх;
- Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- ЗГ-ын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” 190 дүгээр тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гаалийн ерөнхий газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь 2021 онд 6 зорилтын 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 90.6 хувьтай бөгөөд төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хүрээнд харьяа газар, хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд дотоод аудит хийж, зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 64,265.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 963.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Гаалийн ерөнхий газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 614.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн данснүүдэд материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,912.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,884.2 сая төгрөгөөр буурсан байна.

Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн,
аудитын тайлан

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	55.3	20.7	-34.6
Банканд байгаа бэлэн мөнгө	3,796,626.2	1,912,454.8	-1,884,171.4
Дүн	3,796,681.5	1,912,475.5	-1,884,206.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 0.5 сая төгрөг арилжааны банкны дансанд, 1,789.3 сая төгрөг Төрийн сан банкны барьцаа дансанд, 122.7 сая төгрөг Төрийн сан банкны захиалагчийн техник хяналтын зардлын дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа Гаалийн газар, хороодод мөнгөн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

- Дархан-Уул аймаг дахь ГГ албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг баталсан хэмжээнээс 1.2 сая төгрөгөөр илүү тооцож олгосон;
- Говь-Алтай аймаг Бургастай дахь ГХ бичиг хэрэг, архивын эрхлэгчийн 1 орон тоон дээр 2 албан тушаалтан томилж, ажиллаагүй албан тушаалтанд цагийн бүртгэл хөтөлж, 1.3 сая төгрөгийн цалин олгож, зориулалт бусаар зарцуулсан;
- Завхан аймаг Арцсуурь дахь ГХ анхан шатны баримтгүйгээр нэг ажилтанд 1.1 сая төгрөгийн томилолтын мөнгө олгосон байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 80.7 сая төгрөг болж, өмнөх оноос 19.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	521.2	354.1	-319.4
Татаас, санхүүжилтийн авлага	1,011.9	29,452.3	28,441.0
Бусад авлага	60,018.2	50,918.6	-9,099.6
Дүн	61,551.3	80,725.0	19,173.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 35.9 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Завхан аймгийн Арцсуурь дахь ГХ-д 2013-2015 онуудад үүссэн 9.6 сая төгрөгийн авлага нь гэрэл цахилгааны төлбөр;
- Гаалийн ерөнхий газарт 2009-2011 онуудад үүссэн нийт 23.8 сая төгрөгийн авлага нь харилцагч байгууллагуудын мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын мэдээллийн санд байхгүй тул шийдвэрлэх боломжгүй болсон;

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 62.0 сая төгрөг болж, өмнөх оноос 30.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн, аудитын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	31,626.0	62,015.8	30,389.8
Дүн	31,626.0	62,015.8	30,389.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2021 онд үүссэн 62.0 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

- Гаалийн ерөнхий газрын 2021 оны 1 дүгээр улирлын хэвлэл захиалгын зардал 0.4 сая төгрөг;
- Гаалийн ерөнхий газрын Үйлчилгээ, аж ахуйн албаны тайлант онд автомашины даатгалын зардалд шилжүүлсэн төлбөрийг хэсэгчлэн зардлаар хүлээн зөвшөөрснөөс үлдсэн 21.9 сая төгрөг;
- Сэлэнгэ аймаг Сүхбаатар боомтын Нэг цэгийн үйлчилгээний барилга ашиглалтад орохтой холбоотой тохижилтын ажлын төлбөр 39.7 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт: Сэлэнгэ аймаг дахь ГГ нь төсөвт өртгийг хуваан шууд гэрээ байгуулж, төлбөрийг урьдчилан шилжүүлж, 39.7 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар тайлагнасан байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 4,521.7 сая төгрөг болж, өмнөх оноос 133.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын	46,946.3	78,135.1	31,188.8
Эм боох материал	122.0	475.2	353.2
Бэлэн бүтээгдэхүүн	968,680.1	1,026,613.6	57,933.5
Бичиг хэрэг	90,637.3	101,578.0	10,940.7
Аж ахуйн материал	1,614,786.9	1,482,918.2	-131,868.7
Сэлбэг хэрэгсэл	42,343.1	47,346.0	5,002.9
Түлш, шатах тослох материал	117,547.7	139,747.5	22,199.8
Барилгын засварын материал	53.9	26,147.5	26,093.6
Хүнсний материал	21,229.0	28,012.0	678.3
Бусад хангамжийн материал	1,382,755.9	1,486,961.6	104,205.7
Мал амьтад	102,961.0	103,818.5	857.5
Дүн	4,388,063.2	4,521,753.2	133,690.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын /орон нутгийн / төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 26,036.0 сая төгрөгийн ажил бүрэн дуусаагүй хөрөнгө бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа Гаалийн газарт бараа материалын данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

- *ЧХОУНБ дахь ГГ бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 14 нэр төрлийн 16.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн 9.9 сая төгрөгийн тавилга эд хогшлыг бүртгэсэн;*

- Сайншанд дахь ГГ-ын дансанд бүртгэлтэй 420 толгой малыг хөрөнгийн хараат бус үнэлгээний компаниар үнэлүүлэн, зах зээлийн ханшаар үнийг нэмэгдүүлэн бүртгээгүй;
- Дархан-Уул аймаг дахь ГГ дахин ашиглагдах хөрөнгийн шинжтэй 1.4 сая төгрөгийн үнэ бүхий 4 багаж хэрэгслийг тайлант онд зардалд бичсэнийг залруулж бараа материалын дансанд бүртгэсэн.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 132,934.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1,264.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	79,061,276.0	80,582,714.9	1,521,439.0
Тээврийн хэрэгсэл	2,642,770.1	2,194,919.0	-447,851.1
Машин тоног төхөөрөмж	43,467,338.7	40,851,353.9	-2,615,984.8
Тавилга эд хогшил	2,268,367.2	2,064,633.7	-203,733.5
Түүх соёлын дурсгалт зүйлс	7,222.4	7,222.4	-
Номын фонд	55,199.6	55,199.6	-
Бусад үндсэн хөрөнгө	279,324.2	632,337.7	353,013.5
Программ хангамж	788,391.8	824,750.2	36,358.4
Бусад биет бус хөрөнгө	5,629,085.0	5,702,807.8	73,722.8
Дүн	134,198,975.0	132,915,939.3	-1,283,035.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө 14,165.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр балансад шилжүүлсэн 912.0 сая төгрөг, акталсан 2,272.0 сая төгрөг, нийт 3,185.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Сэлэнгэ, Дархан-Уул аймаг дахь ГГ-ууд тайлант онд нийт 6.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцолгүй санхүүгийн тайланд тусгасныг аудитын явцад залруулсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,852.4 сая төгрөг болж, өмнөх оноос 1,400.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ажилчидтай холбогдсон өглөг	18.5	18.5	-
Бараа үйлчилгээний зардлын зардал	9,090.5	592.3	-8,498.2
Бусад өглөг	3,243,564.3	1,851,777.1	-1,391,787.2
Нийт дүн	3,252,673.3	1,852,387.9	1,400,285.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 1,789.3 сая төгрөгийн барьцаа, хугацаа хэтэрсэн 23.4 сая төгрөгийн өр байна. Үүнд:

- Горхи мэлхий хад амралтын газарт 2011 онд Нийслэлийн татварын газраас шалгалт хийж НӨАТ төлөөгүй шалтгаанаар 22.9 сая төгрөгийн акт тогтоосон нь Гаалийн байгууллага шийдвэрлэх боломжгүй өглөгөөр бүртгэсэн;

- Мөн харилцагч байгууллагуудын мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын мэдээллийн санд байхгүй шийдвэрлэх боломжгүй 0.5 сая төгрөгийн өглөг тус тус байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 163,676.5 сая төгрөг болж, өмнөх оноос 2,014.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71,069,406.4	71,069,406.4	-
Хуримтлагдсан үр дүн	83,707,074.9	85,597,657.9	1,890,583.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,885,585.5	6,918,496.7	32,911.2
Дүн	161,662,066.8	163,676,561.0	1,923,494.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүн 1,887.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс голлон нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансны 3.1 сая төгрөгийн залруулга нь Ховд аймаг дахь ГГ дахин үнэлгээ хийсэн хөрөнгө акталж, дахин үнэлгээний нэмэгдэл 2.0 сая төгрөг, ГЕГ болон ЧХОУНБ дахь ГГ нийт 1.1 сая төгрөгийн он дамжсан авлагын тооцоог холбогдох баримтаар баталгаажуулан өмнөх үеийн үр дүнд залруулга хийсэн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс 32.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь УХШИГГ элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгөнд ТӨБЗГ-ын шийдвэрээр дахин үнэлгээ хийж, 34.9 сая төгрөгөөр бүртгэлд тусгасан, Ховд аймаг дахь ГГ дахин үнэлгээ хийлгэсэн хөрөнгө акталж, дахин үнэлгээний нэмэгдэл 2.0 сая төгрөгөөр бууруулснаас голлон нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 79,201.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,227.1 сая төгрөгөөр, нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 80,428.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 25,430.6 сая төгрөгөөр бууруулж 54,997.7 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтыг 6,225.8 сая төгрөг, нийт 61,223.5 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 61,223.5 сая төгрөгийн урсгал төсөв баталснаас 59,996.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,227.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 53,426.8 сая төгрөгийн урсгал зардлын, 6,180.6 сая төгрөгийн хөрөнгийн нийт 59,607.4 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 1,126.4 сая төгрөг, нийт 60,733.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 39,838.7 сая, хөрөнгийн зардалд 6,180.6 сая төгрөгийг тус тус зарцуулж 14,714.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд 1,126.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөг 91.8 хувиар биелүүлж, 100.8 сая төгрөгөөр тасарсан нь Коронавирус /COVID-19/-ийн цар тахлын халдварын нөхцөл байдлын улмаас Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зарим хилийн боомтууд хаагдсантай холбоотой байна.

Хүснэгт.8 Туслах үйл ажиллагааны орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	1,227,147.2	1,126,350.0	-100,797.2	91.8
Нийт дүн	1,227,147.2	1,126,350.0	-100,797.2	91.8

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 46,019.5 сая төгрөг буюу 75.1 хувьтай байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд урсгал үйл ажиллагааны зардлын хүрээнд нийт 15,159.0 сая төгрөг зарцуулагдаагүй байна. Үүнд:

- Гаалийн шинэчлэлтэй холбоотой гаалийн байгууллагын орон тоог 1822 байхаар цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал батлагдсан боловч Ковид-19 цар тахлын улмаас бүтээн байгуулалтын ажлууд удааширч, ашиглалтад орох хугацаа хойшилсон тул шинээр нэмэгдэх орон цалин хөлсний зардал;
- Гаалийн шинэчлэлийн хүрээнд хийж буй бүтээн байгуулалтууд Ковид-19 цар тахлын улмаас ашиглалтад орох хугацаа хойшилсон тул барилга байгууламжуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд;
- Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас худалдан авах нээлттэй тендерийг 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал гараагүй;
- Олон улсын болон бусад байгууллагаас амны хаалт, нэг удаагийн резинэн бээлий зэрэг Ковид-19 цар тахлаас хамгаалах нэг удаагийн хамгаалах хэрэгсэл хандив тусламжаар нийлүүлсэн тул хөдөлмөр хамгааллын зардал хэмнэсэн байна.

Хүснэгт-9 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70205	Татвар хураалт орлого бүрдүүлэлт	61,223,546.4	46,019,305.5	15,204,260.9	75.1
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	50,732,421.9	36,280,640.9	14,451,781.0	71.5
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	1,165,871.2	1,118,723.3	47,147.9	96.0
1.3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	28,997.4	472.5	28,524.9	1.6

Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн, аудитын тайлан

1.4	80219	Харуул, хамгаалалтын зардал	346,664.0	297,415.4	49,248.6	85.8
1.5	80220	Холбооны суваг ашигласны хөлс	1,026,108.0	1,020,107.7	6,000.3	99.4
1.6	80305	Биеийн тамирын тэмцээн, уралдаан	20,000.0	19,827.2	172.8	99.1
1.7	80313	Дээж худалдан авах	377,777.8	2,188.0	375,589.8	0.6
1.8	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	88,482.2	81,231.4	7,250.8	91.8
1.9	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,178,483.8	989,665.6	188,817.7	84.0
1.10	80811	Нүүлгэн шилжүүлэх зардал	32,920.0	28,473.7	4,446.2	86.5
1.11	80918	Бусад /хөрөнгө оруулалт/	6,225,840.1	6,180,559.8	45,280.3	99.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 16.0 сая, Засгийн газрын нөөц сангаас 596.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 5.0 сая, бусад төсвийн захирагчаас 185.4 сая, нийт 803.2 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн шийдвэрээр “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж сурталчлах зорилгоор” нийт 185.4 сая төгрөгийг УБГГ, УХШИГГ, ЧХОУНБ дахь ГГ-уудад хуваарилан холбогдох зориулалтаар зарцуулсан байна.

Мөн Засгийн газрын нөөц сангаас хуваарилсан 589.5 сая төгрөгөөр Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтод хил хяналт, авто тээврийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын ажлын түр байр болон теле хяналтын системийн угсралт, суурилуулалтын ажлыг хийж, хөрөнгөд бүртгэсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан Татвар хураалт, орлого бүрдүүлэх зорилтын хүрээнд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 3,560,200.0 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 3,508,200.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, биелэлт 98.5 хувьтай байгаа нь коронавируст цар тахлын улмаас 2021 оны гаалийн бүрдүүлэлтийн тоо өмнөх оны мөн үеэс 19.5 хувиар буурснаас шалтгаалсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитын гол асуудалд хөндөх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Гаалийн байгууллагын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд 2940 мэдээллийг байршуулахаас 68 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Тухайлбал:

- Шивээхүрэндахь ГГ шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 гүйлгээ мэдээлээгүй;
- Дархан-Уул аймаг дахь ГГ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 гүйлгээг байршуулаагүй;
- Гашуунсухайт дахь ГГ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 гүйлгээг байршуулаагүй;
- Бичигт дэх ГГ шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд нийт 39 мэдээллийг ил тод байршуулахаас 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн;
- ЧХОУНБ дахь гаалийн газар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 135 мэдээллийг ил тод байршуулахаас 2 мэдээллийг байршуулаагүй зэрэг зөрчлүүдэд зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн.

Харьяа байгууллагуудад илэрсэн Нийцлийн аудитын асуудлаар нийт 1,519.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 29.6 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 608.7 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 128.2 сая төгрөгийн зөрчилд 3 хариуцлага тооцох санал, 753.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Гаалийн ерөнхий газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 293.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах тухай 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт. 10 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	293,500.0	1	293,500.0			100.0
Зөвлөмж	1	-	1	-			100.0
Нийт дүн	2	293,500.0	2	293,500.0			100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмжийн шинэчлэлд батлагдсан 1,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэл нь АХГ-2022/10/НА-СТА-ТТЗ

гараагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч, Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа дансанд төвлөрүүлсэн асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,878.6 сая төгрөгийн 71 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 358.7 сая төгрөгийн 64, нийцлийн аудитын асуудлаар 1,519.9 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илрүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 358.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 145.2 сая төгрөгийн 23 алдааг аудитын явцад залруулж, 6.9 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 80.7 сая төгрөгийн 12 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 125.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 23 зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 213.5 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 963.9 сая төгрөгөөс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 21 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 18 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүвэрт хамрагдсан, “Горхи, мэлхий хад” амралтын газар үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар аудитад хамрагдаагүй.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 16, “Хязгаарлалттай” 2 /Говь-Алтай аймаг Бургастай дахь ГХ, Завхан аймаг Арцсуурь дахь ГХ/ дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 286.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 117.5 сая төгрөгийн 19 алдааг аудитын явцад залруулж, 6.9 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоож, 80.7 сая төгрөгийн 12 албан шаардлага хүргүүлж, 81.4 сая төгрөгийн 20 зөвлөмжийг хүргүүллээ.

Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагууд бүтэц, орон тооны хязгаарыг баримталж ажиллаагүй, баталсан орон тоог хэтрүүлж, нийт 645.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

1. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газар батлагдсан орон тооноос 26 албан хаагч илүү ажиллуулж, 171.4 сая төгрөг;
2. Улаанбаатар хот дахь Гаалийн газар батлагдсан орон тооноос 26 албан хаагч илүү ажиллуулж, 228.0 сая төгрөг;
3. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар нь батлагдсан орон тооноос 28 албан хаагч илүү ажиллуулж 234.7 сая төгрөг;
4. Говь-Алтай аймаг Бургастай дахь Гаалийн газар батлагдсан орон тооноос 1 албан хаагч илүү ажиллуулж 11.0 сая төгрөг;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 16.5. “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд дээр дурсан зөрчлийг арилгуулах албан шаардлагыг ГЕГ-ын удирдлагад өглөө.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд 27.7 сая төгрөгийн дараах алдааг залруулав.

ГЕГ-ын дэргэдэх Үйлчилгээ, аж ахуйн алба:

- Агуулахын түрээсийн гэрээний 9.0 сая төгрөгийн дутуу төлөлтийг өглөг үүсгээгүй;
- Урсгал засварын шинж чанартай 18.7 сая төгрөгийн зардлыг хөрөнгө капиталжуулан бүртгэсэн.

4.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт:

Төсвийн урсгал зардлаас 20.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7 "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 "Төрийн өмчийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төсвийн урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх;

Балансын данстай холбоотой асуудал

4.2.2 Илрүүлэлт:

ГЕГ-ын харьяа СХОХ-ийн авлага, өглөгийг тулган шалгахад 1996-2008 онуудад үүссэн авлага, өр төлбөрийг өнөөг хүртэл барагдуулаагүй байна. Тухайлбал: Нэр бүхий 7 байгууллагатай холбоотой 23.8 сая төгрөгийн авлага, нэр бүхий 3 байгууллагатай холбоотой 0.3 сая төгрөгийн өглөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид 1996-2008 онуудад үүссэн авлага, өр төлбөрийг барагдуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;

Дотоод хяналттай холбоотой асуудал

4.2.3 Илрүүлэлт:

Аудитаар нийт 1,806.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6.9 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 689.4 сая төгрөгийн 14 албан шаардлага, 834.9 сая төгрөгийн 23 зөвлөмж өгч, 128.2 сая төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа

эсэхийг хянах" 20 дугаар зүйлийн 20.2.11 "өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах арга хэмжээ авах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулан, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж ажиллах ;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
1	Сэлэнгэ аймаг дахь ГГ	СЭА-2022/223/НА-СТА-ТШЗ	1	1					3	42,756.7	1	1,898.3			1	39,727.0			1	1,131.4
2	Дорноговь аймаг Замын үүд дахь ГГ	ДГА-2022/137/НА-СТА-ТШЗ	1	1					2	12,388.0	1	2,914.0							1	9,474.0
3	Ховд аймаг дахь Булган ГГ	ХОА-2022/31/НА-СТА-ТШЗ	1	1																
4	Дорнод аймаг дахь ГГ	ДОА-2022/183/НА-СТА-ТШЗ	1	1					2	23,024.50	1	23,006.00			1	18.5				
5	Баян-Өлгий аймаг дахь ГГ	БӨА-2022/162/НА-СТА-ТШЗ	1	1																
6	Орхон уул аймаг дахь ГГ	ОРА-2022/35/НА-СТА-ТШЗ	1	1					2	998.1									2	998.1
7	Дархан уул аймаг дахь ГГ	ДАА-2022/126/НА-СТА-ТШЗ	1	1					7	25,854.4	5	19,836.8	1	1,233.0					1	4,784.6
8	Увс аймаг дахь ГГ	УВА-2022/80/НА-СТА-ТШЗ	1	1																
9	Говь-Алтай аймаг Бургастай дахь ГХ	ГАА-2022/68/НА-СТА-ТШЗ	1		1				13	60,293.60	1	19,101.20	3	2,542.20	8	38,650.2			1	-
10	Завхан аймаг дахь Арц суурь ГХ	ЗАА-2022/205/НА-СТА-ТШЗ	1		1				5	25,703.00	1	9,662.40	2	2,037.60					2	14,003
11	Хөвсгөл аймаг Ханх дахь ГХ	ХӨА-2022/231/НА-СТА-ТШЗ	1	1					1	3,700.00									1	3,700.00
12	Сүхбаатар аймаг Бичигт дахь ГГ	СБА-2022/05/НА-СТА-ТШЗ	1	1					4	2038.2	1	776.6	1	134	1	1,127.60				
13	Дорноговь аймаг Сайн шанд дахь ГГ	ДГА-2022/125/НА-СТА-ТШЗ	1	1					8	23,424.10	3	12,264.00			1	1,160.10			4	10,000.00
14	Увс аймаг дахь ГГ	УВА-2022/80/НА-СТА-ТШЗ	1	1																

Гаалийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн, аудитын тайлан

15	ЧХОУНБ дахь ГГ	АХГ-2022/188/НА-СТА-ТШЗ	1	1				3	34,004.40			1	915.6				2	33,088.80
16	УХШИГГ	АХГ-2022/189/НА-СТА-ТШЗ	1	1														
17	Өмнөговь аймаг Гашуун сухайт дахь ГГ	ӨГА-2022/119/НА-СТА-ТШЗ	1	1				1	22,340.00	1	22,340.00							
18	Өмнөговь аймаг Шивээ хүрэн дахь ГГ	ӨГА-2022/120/НА-СТА-ТШЗ	1	1				3	4,969.00	3	4,969.00							
	ДҮН		18	16	2			59	286,400.8	19	117,489.4	8	6,862.4	12	80,683.4		20	81,365.60
19	ГЕГ-ын дэргэдэх СХОХ	АХГ-2022/10/НА-СТА-ТТЗ	1	1				2	24,103								2	24,103
20	ГЕГ-ын дэргэдэх ҮААА	АХГ-2022/10/НА-СТА-ТТЗ	1	1				3	48,150.70	2	27,750.00						1	20,400.70
	Дүн		2	2	0	0	0	5	72,253.70	2	27,750.00						3	44,503.70
	Нийт дүн		20	18	2			64	358,654.5	23	145,239.4	8	6,862.4	12	80,683.4		23	125,869.3

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс													
			Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж					
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн				
1	Дархан уул аймаг дахь ГГ	ДАА-2022/126/НА-СТА-ТШЗ	1	93,092.5													1	93,092.5
2	Говь-Алтай аймаг Бургастай дахь ГХ	ГАА-2022/68/НА-СТА-ТШЗ	2	38,484.0	1	29,640.6				1	8843.4							
3	Сүхбаатар аймаг Бичигт дахь ГГ	СБА-2022/05/НА-СТА-ТШЗ	1	648,670.10													1	648,670.1
4	ЧХОУНБ дахь ГГ	АХГ-2022/188/НА-СТА-ТШЗ	1	128,186.0								1	128,186.					
5	Өмнөговь аймаг Гашуун сухайт дахь ГГ	ӨГА-2022/119/НА-СТА-ТШЗ	1	11,700.0													1	11,700.0
6	Өмнөговь аймаг Шивээ хүрэн дахь ГГ	ӨГА-2022/120/НА-СТА-ТШЗ	1	599,818.8						1	599,818.8							
	Дүн		7	1,519,951.4	1	29,640.6				2	608,662.2	1	128,186.0			3	753,462.6	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 704/А0150053
АХГ-2022/10/СТА-ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-т заасны дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагууд бүтэц, орон тооны хязгаарыг баримталж ажиллаагүй, баталсан орон тоог хэтрүүлж, нийт 645,094,700.00 төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

1. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газар батлагдсан орон тооноос 26 албан хаагч илүү ажиллуулж, 171,455,300.00 төгрөг;
2. Улаанбаатар хот дахь Гаалийн газар батлагдсан орон тооноос 26 албан хаагч илүү ажиллуулж, 227,995,300.00 төгрөг;
3. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар нь батлагдсан орон тооноос 28 албан хаагч илүү ажиллуулж 234,714,200.00 төгрөг;
4. Говь-Алтай аймаг Бургастай дахь Гаалийн газар батлагдсан орон тооноос 1 албан хаагч илүү ажиллуулж 10,929,900.00 төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 16.5. “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах шаардлагатай орон тоог дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхыг Гаалийн ерөнхий газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Долгорсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЦЭРЭНХҮҮ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

4006109
9019120396

\\0.10.10.11\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0325_Audiin_2_Gazar-350.Docx

0001082000

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing the summary.

